

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-18

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 3-18

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 14-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 23 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Болорчулуун, Н.Наранбаатар, Д.Өнөрболор;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Ганибал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат үг хэлэв.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Дэнсмаа, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, мэргэжилтэн Э.Цолмон, нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Б.Дашням, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэмбилэг, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Д.Дэчин, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Отгонцэцэг, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Болдбаатар, Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Мал эмнэлгийн ерөнхий

газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Нарантуяа, мөн газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Б.Саранчимэг, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэмбилэг, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Д.Тунгалаг нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 23 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Сарангэрэл: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 52,6 хувьтай болсон тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя. Тилеуханы Аубакир гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Гочоогийн Ганболд гишүүн ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Батсүхийн Саранчимэг гишүүн ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна. Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна.

Та бүхэнд Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Засгийн газар 2023 оны 6 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Тэгэхээр 2 дахь хэлэлцүүлэг санал, дүгнэлтээ Төсвийн

байнгын хороонд хүргүүлэх ийм учиртай. Тийм учраас эхний асуудлаа та бүхэнд танилцууллаа.

2 дахь асуудал Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн бас санаачилсан байгаа. Тэгээд ийм 2 хэлэлцэх асуудалтай байгаа. Тэгэхдээ энэ хэлэлцэх асуудал дээр 2 дугаар асуудал дээр төсөл санаачлагч өөрөө хойшлуулах санал гаргасан байгаа тул энэ асуудлыг хойшлуулна. Тэгэхээр бид нар бол хэлэлцэх нэг асуудалтай байна. Тэгэхээр хэлэлцэх асуудал дээр холбогдуулаад санал хэлэх гишүүд байна уу? Идэрбат гишүүн байна. Идэрбат гишүүн саналаа хэлье. Идэрбат гишүүний микрофоныг өгье. Идэрбат гишүүн юугаа яасан бэ, та картаа үз дээ.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэндийг хүргэе. Би энэ удаагийн Байнгын хороо гэхээсээ илүү дараагийн Байнгын хороон дээр бас нэг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд одоо оруулж өгөөд бэлтгэл ажлыг нь хангуулаач гэсэн нэг санал байгаа юм. Юу гэхээр өнгөрсөн Байнгын хорооны хуралдаан дээр Хөдөө аж ахуйн яамныхантай энэ малын хорогдол, тэр дундаа малчдын даатгалын асуудлаар бас тодруулга авсан. Тавхан минутад хариулт авсан. Тэндээс бас нэлээн тийм хачирхалтай дүр зургууд хариултаас гарч ирж байна лээ. Тийм учраас одоо ингээд улс орон даяар хагас жилийн малын тооллого дуусаж байгаа. Энэ өвлийн, хаврын хүндийг, дээрээс нь байгаль цаг уурын гэнэтийн аюул осол гээд олон зүйлээс болж энэ мал сүрэг бол нэлээн осолдсон, хорогдсон. Тэгэхээр малчдад яг ийм үед туслах, ийм үед бас малчдын эрсдэлийг хуваалцах ёстой энэ даатгалууд, даатгалын компаниудын үйл ажиллагааны асуудлаар Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас бас нэлээн тодорхой томоохон танилцуулга юмнуудыг авъя гэсэн ийм саналыг би дэвшүүлж тавих

гээд байгаа юм. Дэвшүүлж тавих гээд байгаа юм. Түрүүчийн хариулт бол би яах вэ нөгөө 5 минутад нөгөө хүн маань хариулах гэж маш бүрхэгдүү, бүрхэгдүүдээ бас нэлээн бас нэлээн сайн ухааж үзэх ёстой, сонсох ёстой ийм хариултыг сонссон учраас дараагийн Байнгын хорооны хуралдаан дээр энэ асуудлыг оруулж өгөөч гэсэн ийм хүсэлт тавих гэсэн юм. Баярлалаа.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүний саналыг хүлээж авлаа. Тэгэхээр энэ саналыг бас Даргын зөвлөлөөр оруулаад хэлэлцүүлэх мэдээлэл сонсох тал дээр анхаарна. Тэгээд ер нь бол бас энэ манай харьяаны яамд, тамгын газрынхан өөрсдөө бас Байнгын хороонд оруулж ирэх материалаа эрт хүргэж, мэдээллээр хангаж, мэдээллээ бас сайн хийж байхыг хүсэж байна. Тэгээд цаашидаа бас энэ дээр бас анхаарч ажиллах ёстой. Өөр хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байхгүй учраас хэлэлцэх асуудлаа баталъя. Санал хураалт байхгүй, санал хураалт байхгүй. Байхгүй зүгээр санал хураалт гэж хэлээгүй дээ энэ юуныхан операторууд сайн анхаарч яагаарай.

Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Наашаа өг дөө. Өнөөдөр бас Засгийн газрын хуралтай байгаа. Одоо Жавхлан сайд, Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 2 ирж байгаа.

Бусад ирсэн ажлын хэсгийн гишүүдийг бас танилцуулж байя. Зулхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Занданбат Монгол Улсын аудитор, орлогч нь Наранчимэг Монгол Улсын аудитын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Самбууням Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэлийн-нийслэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Сангийн

яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн Бодлогын хэрэгжилтийг дарга, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны төсвийн хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга, Төгөлдөр Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цолмон Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Дэнсмаа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Дашням Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хаана байна вэ? Энхтүвшин Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Болдбаатар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганзориг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга, Эрдэмбилэг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дэчин мөн яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Болорчулуун сайд хаана байгаа юм бэ? Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Болорчулуун мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Отгонцэцэг мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Тунгалаг Мал

эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга гэсэн байна.

Ажлын хэсгийнхнийг танилцууллаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан танилцуулна. Та микрофон юун дээрээ, карт, Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7,9 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3,8 тэрбум долларт хүрч сайжраад байна. Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого, амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа. Тухайлбал 1.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгоно. 2-т тэтгэврийн зөрүүний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх. 3.Төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж, суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх. Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын сүлжээг

өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 1,7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1,1 их, 1,8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт зардал алдагдал 1,6 их наяд төгрөг буюу анх батлагдсан ДНБ-ий 2,6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөлөө.

Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Саранчимэг: Жавхлан сайдад баярлалаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг танилцуулна. 2 номерын микрофоныг өгье.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллага дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781000,9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34,5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371,4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37,2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589,5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2,6 хувь байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсөв 2023 оны батлагдсан төсвөөс 30 тэрбум төгрөгөөр, хөдөө аж ахуй, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсөв 10 тэрбум төгрөгөөр тус тус өөрчлөлт оруулж орсон байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын төсөв нийт 40 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн албан хаагчийн цалин хөлсийг шинэчлэн тогтоосон ажил олгогчдоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн байгаа нь голлон нөлөөлжээ.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн шаардлагыг хангасан байна гэж дүгнэлт гаргалаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Сарангэрэл: Наранчимэг даргад баярлалаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах энэ төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Тэгэхээр хууль санаачлагчаас болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух

асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Ганболд гишүүнээр тасаллаа. Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Төсвийн тодотгол орж ирж байна. Тэгээд орон нутагт ялангуяа энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороотой холбоотой яг энэ хүмүүсээс бол нэлээн асуудал тавьж байгаа. Тэр нь юу гэхээр энэ цалингийн ялгамжтай байдал. Өөрөөр хэлбэл энэ цалингийн сүлжээний ялгаатай байдал. Улсын төсвийн тодотгол дээр бол хөрөөний ир шиг гэж томьёолж байна лээ. Тэгээд энэ бол яг ийм байдал байгаа. Тэгэхээр энэ удаагийн энэ тодотгол бол энэ байгаль орчны салбарт, хүнс, хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн цалинг ер нь зөрүүгүй болгож ойртуулах ийм арга хэмжээ авч байгаа юм байна. Тэгээд энэ танилцуулга дээр бол манай Байнгын хорооны танилцуулга дээр энэ цалингийн доод хэмжээг 1 сая төгрөг, тэнд бас ажилладаг энэ төрийн үйлчилгээний бид нар ТҮ-ийнхэн гэж ярьдаг энэ хүмүүсийн цалингийн доод хэмжээг бас 750 мянган төгрөг болгоно энэ тэр гээд ийм зүйлүүд оруулж ирж байна. Тэгэхээр энийг бол дэмжиж байгаа. Өөрөөр хэлбэл орон нутагт ажиллаж байхад энэ цалин хүрэхгүй байдал ажиллангаа ядуурч байна гэж би хэлээд байгаа. Тэгэхээр юмны үнийн өсөлт энэ тэр чинь бол тэр авч байгаа цалинтай бол ерөөсөө нийцэхгүй байна. Төрийн албан хаагчид бол маш их хэмжээгээр ажлаасаа гарч, гадаад руу ажиллахаар энэ тэр явж байгаа. Энэ чинь бол бодитой үнэн.

Дээрээс нь яг энэ салбарын үйл ажиллагааг явуулж байгаа хүмүүс ялангуяа энэ сумдын хөдөө аж ахуйн газрын тасгийн 3 мэргэжилтэн, мал эмнэлгийн тасгийн 2 мэргэжилтэн нийлээд энэ 5 хүнээс 5-уулаа байгаа газар бараг байхгүй. 1 юм уу 2, 1 юм уу 2 хүн л ингээд байгаад байгаа. Тэгэхээр энэ чинь энэ цалинтай холбоотой асуудлууд орж ирж байгаа. Тэгэхээр яг салбарынхнаас нь бол энэ юунаас Хөдөө аж ахуйн яамныхнаас Хөдөө аж ахуйн тасаг болон

мал эмнэлгийн тасагт ажиллаж байгаа хүмүүсийн доод цалин яг энэ түвшинд хүрч чадаж байгаа юу? Та нар өөрсдөө энэ дээрээ хяналт тавьж байгаа юу? Дээрээс нь олон жилийн нэмэгдлүүд нь бас нэмэгдээд явах уу гэдэг нэг ийм асуулт байна.

Дараагаар нь энэ хүмүүс яг энэ салбарт ялангуяа энэ малын эмч, зоотехникч, агрономич гэсэн энэ мэргэжилтэй хүмүүс бол бүр нүдний гэм болж байгаа юм, олдохгүй болсон. Тэгэхээр ер нь бол энэ байдлыг нь ингээд хүмүүстэй нь уулзаад яриад байхаар ер нь бол хуучин бас энэ дундын мэргэжилтэн гэж ярьдаг. Дундын зоо, малын бага эмч, агротехникч гээд энэ хүмүүсийг ерөөсөө бэлтгэхээ больчихсон. Энэ мэргэжлээр хүмүүс сурахаа больчихсон байна. Тэгэхээр энэ дутагдал чинь энэ дээр гараад байна. Энэ дээр бас яг энэ төсөвт, төсвийн тодотголтой холбоогүй ч гэсэн бас энэ салбарын яамнаас нь бас ямар бодлого барьж байгаа вэ?

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан байж байгаа учраас энэ малчдын тэтгэвэр дээр ер нь яг нэмэгдэл яг тоо нь хэд орж ирэх вэ? Манай малчид чинь НДШ бага төлөөд ингээд цөөхөн хүн тэтгэвэр авч байгаа. Тэгэхээр энэ дээр тодорхой нэмэгдэл гарч ирэх үү гэдэг асуулт.

Дээрээс нь энэ малын эмч, зоотехникч, агрономчоор ажиллаж байгаад тэтгэвэртээ гарчихсан нэлээн олон хүн байгаа. Одоо тэтгэвэр аваад явж байгаа яг энэ мэргэжлүүдээр. Энэ хүмүүсийн тэтгэвэр дунджаар хэд байгаа, ямар хэмжээгээр нэмэгдэж байгаа вэ гэдэг энэ асуултыг асууя.

3 дугаарт нь энэ юун дээр Нийгмийн даатгалын багц хууль явж байгаа. Төсвийн тодотгол явж байгаатай холбогдуулаад Булгантуяа сайд байна. Тэгэхээр энэ дээр тэр нөгөө төрөөс олгох урамшуулаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцох гэдэг хууль батлагдаад гарчихсан,

10 сарын 1-нээс хэрэгжих гэж байгаа. 10 сарын 1 чинь тун удахгүй болно. Энэ дээр бэлтгэл ажлыг одоо яг энд хамааралтай салбарын яам, 2 яам нь орж ирчихсэн байгаа үе дээр бэлтгэл ажил хангагдаж байна уу? Бид хэд зунжин наадамдаж байгаад ирэхэд л энэ 10 сарын 1 чинь болно. Тэгээд энэ талаар бас.../минут дуусав/

Б.Саранчимэг: Хэн хариулах вэ? Хэдэн номер юмт бэ? 3 номер хариулъя.

С.Зулхар: Байнгын хорооны гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтган мэндчилье. Улсын Их Хурлын гишүүн Тувааны асуултад хариулъя. Малчдын тэтгэвэртэй холбогдуулсан асуулт асуугдаж байна. Нийт тэтгэвэр авагчдын тухайд бол хамгийн багадаа 10 хувиар бол нэмэгдэж байгаа. Энэ бол 10 хувийн нэмэгдэл бол бүх тэтгэвэр авагчтай холбоотой. Нөгөөтээгүүр бид энэ удаагийн тэтгэврийн нэмэгдэл дээр итгэлцүүрийг шинэчлэн тогтоох байдлаар бол тэтгэвэр нэмэх ийм бас зарчим баримталж байгаа. Энэний дагуу тухайн малчид маань тэтгэвэрт гарахдаа төлсөн шимтгэлийг нь өндөр байх юм бол энэнтэй уялдсан байдлаар нь бол тодорхой малчдын хувьд тэтгэвэр нэмэгдэх ийм бас боломж бий гэдгийг хэлье. Гэхдээ энэ бол нийтдээ бол 164 мянган жишээ нь тэтгэвэр авагчдын тухайд яригдаж байгаа учраас тэрэн дотор ямар малчин орох нь бол тухайн үед бол жишээ нь тооцоологдоод ингээд явна гэдгийг хэлье.

Нийгмийн даатгалын багц хуулийн тухайд ажлын хэсэг ажиллаж байгаа. Их Хурал дээр ч гэсэн ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэрнээс гадна манай 3 талтын тогтоолтын түвшинд бол энийг бол маш сайн хэлэлцэж байгаа. Нөгөөтээгүүр жишээ нь салбар салбараар нь бас энэ хуулийн төслийг хэлэлцүүлж, саналуудыг нь аваад явж байгаа. Хууль бол өргөн баригдсан, хэлэлцэхэд бэлэн болсон. Тэрнээс гадна энэ хуулийн хэлэлцүүлэх явцад бол гарсан бүх саналуудыг бол нэгтгээд ажлын хэсэг бол бэлэн болгосон

байгаа. Ямар ч үед бол хэлэлцээд энийг бол бид бол үр дүнгийн талаар танилцуулаад бас тодорхой шийдвэр гаргахад бол бэлэн болгосон гэж ойлгож байгаа. Баярлалаа. Нийгмийн даатгалын багц хуулийг.

Б.Саранчимэг: Сангийн яамнаас нэмж хариулах уу? Туваан гишүүн болсон уу? Хөдөө аж ахуйн яамнаас хариулъя, 5 номерын микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Туваан гишүүний асуултад хариулъя. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэр 2023 онд нийтдээ 2094 орон тоотойгоор 31,4 тэрбум төгрөгийн цалингийн сантай ажиллахаар манай салбарт бол батлагдсан байгаа. Үүнээс бол 673 төрийн албан хаагч ажиллаж байгаа бол нийт ажиллагсдын 32,1 хувийг бол эзэлж байгаа. ХХААХҮ-ийн сайдын ерөнхийлөгчийн ерөнхийлөгч нь, ерөнхийлөн захирагчийн төсөвт бол 52 байгууллагын цалингийн тайлан хамаарагддаг байгаа. Энэ хүрээнд бол орон нутагт байгаа энэ манай салбарын ажилчдын цалингууд бол энэ гарч байгаа нэмэгдэж байгаа нийтийн жишгийн дагуу бол нэмэгдээд явж байгаа гээд хэлье.

Салбарын боловсон хүчний асуудал бол бид нэлээд тулгамдаж байгаа асуудал байгаад байгаа. Тэгэхээр энэ салбарын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын боловсон хүчний талаар ажлын хэсэг байгуулагдаж, холбогдох мэргэжлийн холбоод, сургуулиудыг оролцуулаад томоохон ажлын хэсэг байгуулаад энэ хавраас хойш ингээд ажиллаад ерөнхийдөө нэг дүр зургаа гаргаад ирсэн байгаа. Тэгээд энэ ажлыг бол бид олон нийтийн хэлэлцүүлэг хийгээд улмаар Байнгын хороо, Засгийн газарт танилцуулаад явъя гэж ингэж тооцоолж байгаа. Тэгэхээр одоо бол салбарт яг боловсон хүчин дээр хаана ямар дутагдал байгаад байна, хаана нь ямар эрэлт байгаад байна гэдэг энэ тооцоо судалгаануудыг бол ерөнхийд нь гаргасан.

Цаашилаад бид нар боловсон хүчнийхээ бодлогыг дээд боловсролын түвшинд аль, аль мэргэжлээр бидэнд шаардлагатай боловсон хүчний дутагдал байна, дунд, дунд түвшиндээ ямар МСҮТ-ээр бэлтгэгдэх ямар боловсон хүчний шаардлага байна гэдгийг тооцоолж гаргасан. Дээрээс нь бас энэ салбарын онцлогт цаг үеийн ажилд шаардлагатай тухайлбал хаврын тарилга, туулга, малын вакцинжуулалтад боловсон хүчний дутагдлууд байгаад байна. Намрын ургац хураалтад ажиллах боловсон хүчнүүдийг оюутан цэргүүдийг хэрхэн яаж дайчлах вэ гээд ингээд үндсэндээ 3 багц болгоод энэ ажлын хэсэг дээр ерөнхий төлөвлөгөө гаргаад ирсэн байгаа. Тэгээд энийгээ бол гаргасан энэ төлөвлөгөөгөө хэлэлцүүлээд, цаашидаа энийг бас Засагт танилцуулаад, Байнгын хороонд танилцуулаад явъя гэсэн ийм төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байгаа. Тэгээд энэ дээр мэдээж зөвхөн боловсон хүчний дутагдал эрэлт, нийлүүлэлтээс гадна боловсон хүчнийг хэрхэн яаж тогтвор суурьшилтай ажиллуулах вэ, урамшууллын ямар тогтолцоо байх вэ гээд энэ олон талын асуудлуудыг бол авч үзсэн байгаа гэдгийг л. Төрөөс олгох урамшуулал, урамшуулалтай холбоотойгоор бид нар бас холбогдох яамтайгаа хамтарч ажиллаж байгаа. Энэ бэлтгэл ажлуудыг бол хангаад явж байгаа.

Б.Сарангэрэл: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тэр юун дээр хуулийн бэлтгэл дээр энэ хүн амын юу, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бас нэмэлт юу авчихъя бэлтгэл дээр. Энэ 2 яам энийг хэрэгжүүлнэ гэдгийг хэлчихье. Энэ дээр нэмэлт авъя. Дээрээс нь энэ Байгаль орчны яаман дээр Ус, цаг уур, орчны шинжилгээний газраас хүн бас байх шиг байна. Энэ дээр энэ сум дээр сумууд дээр томоохон дээр энэ цаг уурын өртөө гэж байна. Өртөөгүй сумууд дээр цаг уурч гээд хүмүүс байна. Энэ хүмүүсийн цалин яг хэд болж нэмэгдэж байгаа вэ? Тэгээд энэ хүмүүсээ ер нь та хэд тоож яадаг юм уу? Тэр нийгмийн асуудлуудыг нь энэ тэр

нь ярьдаг юм уу, ер нь энэ хүмүүс чинь нэг тийм эзэнгүй л юм шиг ингээд явцгаагаад байх юм. Энэ дээр энэ УЦУОШГ хариулт өгөөч. Дээрээс нь байгаль хамгаалагчдын нэг хамгаалагчдаас төрийн албан хаагчийн шалгалт авна гээд байсан за тэр нэг юм болсон юм шиг байна. Байгаль хамгаалагчдын цалин яг тодорхой хэдэн төгрөг болж нэмэгдэж байгаа вэ? Энэ дээр тодорхой тооны хариулт аваадахъя.

Б.Саранчимэг: 5 номерын микрофоныг өгье. Өөрийгөө танилцуулаад асуултад хариулчхаарай.

С.Энхтүвшин: ЦУОШГ-ын дарга Энхтүвшин. Туваан гишүүний асуултад хариулъя. Манай цаг уурын ус, цаг уур орчны хяналт шинжилгээний системд бол ер нь 137 сумд 5 хүнтэй цаг уурын өртөө ажиглаж байгаа. 181 сумд ганцхан хүнтэй цаг уурын харуул гэж ажиглагч ажиглаж байгаа. Нийтдээ 300 гаруй сумд байж байгаа. Энэ хүмүүсийн нийгмийн асуудал талаар бол бид бол ярьдаг, байнга л ярьж байгаа, анхаарч байгаа, эргэж тойрч байгаа. Тэгэхдээ ганц хүнтэй хөдөө аж ахуйн цаг уурын харуул гэдэг нэртэй энэ харуул бол ихэнх нь бол ажлын байр байхгүй. 1 хүнд зориулсан тэр Тамгын газартай яах вэ зарим нь ярьж барьж байгаад нэг өрөө, нэг ширээ, сандалтай газар бий л дээ цөөхөн газар. Өртөөд бол яах вэ өөрийн гэсэн байртай. Тэгэхдээ 70, 80 оноос хойш л баригдсан барилгууд, маш их хүнд нөхцөлд. Сүүлийн 3, 4 жил бид нар асуудал тавиад, засварынх нь хөрөнгийн асуудал дандаа Их Хурал дээр очоод хасагдчихдаг маш хэцүү байдалд байгаа.

Энэ хүмүүсийн цалин бол доод тал нь 1 сая төгрөг болж байгаа. Энэ шинэ төсвийн тодотголоор, 1 сая 2 мянга. Манай анхан шатанд ажиглаж байгаа ажиглагчийн цалин 766 мянга байсан нэмэгдээд 250 орчим мянгаар нэмэгдээд 1 сая төгрөг болсон. Тэгээд хүмүүс бас уржигдар бас нэгдсэн байдлаар цахим хурал хийгээд бүгдэд нь танилцуулсан. Бүгд их нэлээн баяртай хүлээж авч байгаа гэж ингэж байна. Тэгээд энэ инженерүүд, тэр өртөөний дарга нь бол

сая 100 хэдтэй. Тэгээд инженерүүдийн цалин бол сая хоёр зуун хэдтэй, ер нь нэлээн сайн нэмэгдсэн энэ манай салбарын цалин бол энэ төсвийн тодотголоор.

Б.Саранчимэг: Байгаль орчны яамнаас нэмж хариулах уу? 3 номерын микрофоныг өгье.

С.Зулхар: Туваан гишүүний асуултад нэмэлт тодруулга хийе. Туваан гишүүний санаачлан батлуулсан хуулийн хууль байж байгаа Малчдын түүхий эдийн урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэлийг жишээ нь төлүүлэхтэй холбоотой. Энэ хүрээнд бол 3 яамны хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан, журмаа боловсруулж байна. Бид бол хуулийн дагуу хуулийн хэрэгжилтийг 10 сарын 1-нээс хангаад явах ёстой, бэлтгэл бол хангагдсан гэж та ойлгож болно. Журам бол Засгийн газраар батлагдаад энэ хэрэгжинэ.

Б.Саранчимэг: Булгантуяа сайд нэмж хариулах уу? Булгантуяа сайдын микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Байгаль орчны сайд, Төрийн нарийн бичгийн даргатайгаа яг энэ төсвийн тодотголыг хийх үед бас ирж тусгайлан уулзсан салбарынхаа албан хаагчдын асуудлаар. Энэ дээр цаг уурчдын цалингийн асуудлаар, ангилал зэрэглэлийн асуудлаар сая энэ долоо хоногийн нэг дэх өдөр Ерөнхий сайд бас төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчидтай өглөөний уулзалт хэлцэлд хийсэн. Цаг уурчдаас бас төлөөлөл орон нутгаас, агентлагаас энэ тэр ирж бас хүмүүс бас уулзсан. Тэгээд түүрүүн хэлсэнчлэн цалинг бас төрийн нийтлэг үйлчилгээний цалинг нэмж байгаатай холбогдуулаад бас нэлээдгүй сайн нэмэгдсэн.

Байгаль хамгаалагчийн хувьд яам нь ингэж 2 хуваая гэж ярьсан юм. 1 дүгээрт нөгөө байцаагчийн эрхтэй хүмүүс нь болохоороо төрийн захиргааны ажилтан байхгүй бол болохгүй байна.

Тэгэхээр тэр хэсэг нь бол төрийн захиргаа дээрээ үлдээд, орон нутагт бүүр ингээд байгаль хамгаалагч гээд ойгоор яваад ингээд ажилладаг хүмүүс бол нөгөө төрийн захиргааны албан хаагч гэхээр дээд боловсролтой байх ёстой, төрийн албаны шалгалт өгсөн байх ёстой гээд ингээд шаардлагыг нь хангахад их хэцүү юм байна. Тэгээд манай албан хаагчдын юу бүрдэхгүй байна бид нар ингээд зарлаад, зарлаад энэ шаардлагыг нь хангах хүмүүс бүрдэхгүй байна.

Б.Саранчимэг: 5 номер Байгаль орчны яамнаас нэмж хариулъя.

Г.Эрдэмбилэг: БОАЖЯ Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Эрдэмбилэг. Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. ТЗ-ээр цалинжиж байгаа байгаль хамгаалагчийн цалин үндсэн цалин сая 200 мянга болж байгаа. Тэгээд энэ дээр зэрэг дэв, ажилласан жил, орон нутгийн нэмэгдэл, илүү цагийг ингээд дунджаар нь тооцоод үзэхээр бодогдсон нийт цалин 2 сая орчим болж байгаа. Тийм, туслах байгаль хамгаалагч гээд ТҮ-ээр цалинжих бас албан хаагчид гарч ирж байгаа. Тэр нь бол 1 сая хүртэл төгрөгөөр цалинжих байх, үндсэн цалин тийм.

Б.Саранчимэг: Баярлалаа. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Засгийн газар ингээд цалин, тэтгэврийн ялгаа дээр бас нэлээн өөрчлөлт хийгээд ороод ирж байгаа нь сайшаалтай байна. Нэг зүйлийг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдаас Булгантуяа сайдаас асуугаадахъя. Энэ төрийн албан хаагчдын цалин доод тал нь 1 сая болж байгаа юм байна. Орон нутагт яг ямар байгаа билээ гэдгийг та бүхэн маань ер нь хэр харж байгаа вэ? Ер нь бол сум болгонд 2-оос 3, 4 орон тоо хоосон байгаа шүү дээ төрийн албан хаагчдын. Энийгээ та бүхэн яг яаж харж байгаа вэ? Тэгээд одоо бид нар чинь юу яаж байгаа билээ хот, хөдөөгийн сэргэлт гэж ярьж байгаа. Тэгээд яг энэ хүрээндээ бид нар бас бодож байгаа,

санаж байгаа юм байна уу, үгүй юү? Төрийн албан хаагчид яагаад тэнд орон нутагт тогтохгүй байгаад байгаа юм бэ? Мэдлэггүй, боловсролгүйдээ байгаад байна уу эсвэл үнэхээр цалин мөнгө дутуудаа байгаад байна уу? Нэг талаас бол цалин мөнгө дутуудаа байгаад байгаа юм наадах чинь. Тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

Ер нь бол санхүүгийн дэмжлэг үзүүлж байж хаана сайгүй бол аливаа ажил бол явдаг ийм хөгждөг гол суурь чинь бол бас санхүүдээ байгаа шүү дээ. Тэгэхээр энэ орон нутагт ажиллаж байгаа тэр тусмаа сумд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалинг 1.5, 2 сая болгочоод яагаад болохгүй байгаад байгаа юм бэ? Ингэж байж бид нарын тэр нөгөөдөх хот, хөдөөгийн чинь сэргэлт гэдэг юм чинь явах ёстой шүү дээ. Энэ рүү зорих ёстой тэр 2 сая руу зорих ёстой, сая 500 руу зорих ёстой. Тэгээд энэ дээр яг нэг бодлого ямаршуу байна гэдгийг нэг хэлээд өгөөч. Цаашидаа яах юм бэ, нэмэх юм уу, яах юм бэ? Тэнд эсвэл одоо ингээд л явж л байг л уу, тэнд нэг 2, 3 хүмүүс ингээд орон тоо нь ингээд дутуу явж л байг уу? Энэ дээр нэг бүүр тодорхой хариулт хэлж өгөөч.

2 дугаарт тэр тэтгэврийн тэтгэвэр авагчдын итгэлцүүртэй болчихлоо гээд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас бас яриад байна. Энэ итгэлцүүр чинь нөгөө хуульдаа яг яаж уялдаж орж ирж байгаа вэ? Зүгээр нэг удаагийн хэдүүлээ итгэлцүүрээ ингээд бодчихсон байгаа юу? Журам гаргаж байгаа юу эсвэл хуульдаа суух уу? Одоо орж ирэх гэж байгаа багц хууль дотор чинь суух юм уу эсвэл нэг удаагийн арга хэмжээ дээр хэдүүлээ итгэлцүүрээ бодчихож байгаа юм уу? Дахиад нэг алдаа гарах вий дээ энэ чинь. Бид нар тэтгэврийн доод хэмжээг 500 болгоё гэж татангуутлаа, нөгөө тэтгэврийн зөрүүгээ бол маш ялгаагүй болгоод хаячихсан юм шүү дээ. Өчнөөн 30 жил, 40 жил ажиллаж байгаа хүмүүсийг маань бас гомдолтой үлдээгээд. Дээрээс нь бас тэтгэвэр тэглэлээ яалаа бас нэг арга

хэмжээ хийхдээ бас гомдолтой, гомдолтой үлдээгээд явсан. Одоо энэ дээр бас тийм ялгаа гарах вий дээ. Энэ чинь нэг удаагийн биш би бол итгэл үнэмшилтэйгээр цаашидаа яг энэ итгэлийг чинь бүүр бодитойгоор хэрэгжээд явах өөрчлөлт орж байгаа гэж би бол ойлгоод байгаа шүү дээ. Энэ дээр бас 2 дахь хариулт өгөөч.

3 дугаарт Хөдөө аж ахуйн яам маань нэг асуултад хариулж өгөөч. Малын өвчин маань хэр явж байгаа вэ? Хөдөө бол нуль, нуль малын өвчин болчихоод байна шүү. Тэгээд бид нар МАА-гаа сайжруулна гээд байгаа, 2 дугаарт яг энэ хаврын нөгөө нэг махны үнэ өсөж байгаа чинь бас энэтэй уялдаатай, нийлүүлэлт байхгүй болчихсон. Хавар тарчиг хатуу болоод нийлүүлэлт нь 1 дүгээрт зогсчихлоо, 2 дугаарт ерөөсөө борлуулалтад гардаг малгүй болох гээд байна шүү дээ энэ чинь. Тэгэхээр энэ МАА тал дээрээ тэр тусмаа малынхаа энэ өвчинтэй бүүр хувьсгал гаргах хэрэгтэй байна шүү дээ одоо хэчнээн хэлэх юм бэ та нарт. Тэгээд энэ тодотгол дээр энэ урсгал зардал гээд баахан орж ирж байна. Бараа, үйлчилгээний зардал 150 тэрбум гээд харагдаж байх шиг байна. Хөрөнгийн зардал 74 тэрбум гээд харагдаж байх шиг байна. Нөгөө бид нарын Байнгын хороон дээрээс энэ Хөдөө аж ахуйн байнгын хороон дээрээс бид нар чинь гаргасан шүү дээ, тогтоол гаргасан тийм үү. Жилдээ 2 удаа малдаа вакцинжуулаад ер нь бол малынхаа өвчин дээр хувьсгал хийгээд нэг 3-5 жилийн хугацаанд бол бүх малдаа юу бүрэн вакцинжуулалт хийгээд, нэг сайхан эрүүл малтай больё гэж ярьсан шүү дээ хэдүүлээ. Тэгээд мөнгө төгрөг чинь хэр сууж байгаа юм бэ, яг өнөөгийн байдлаар энэ урсгал зардлууд дотор чинь хэдэн төгрөг вакцинжуулалтад чинь хэдэн төгрөг суучихсан байна вэ, тэр малын эмчид өгч байгаа зардал дээр нь хэдэн төгрөг суучихсан байна вэ, тэр яг малын эмч нарын.../минут дуусав/

Б.Сарангэрэл: Маш тодорхой асуултууд асуулаа. Эхлээд Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Бат-Эрдэнэ сайдын хэлж байгаагаар төрийн албан хаагчдын сая энэ цалинг бас дорвитой нэмэгдүүлж байгаа Засгийн газрын шийдвэр бол төрийн албан албанд тогтвор суурьшилтай ажиллах хүмүүс их хэцүү болсон. Энэ бол ганцхан сумдад гэлтгүй, Улаанбаатар хотод ч мөн адилхан байгаа. Яагаад гэвэл одоогийн энэ цалингийн хэмжээ бол амьдралын амьжиргааны түвшин зардал өндөртэй Улаанбаатар хотод ч амаргүй байж байгаа. Энэ 2 шалтгаантай юм байна гэж бид нар хараад байгаа юм Бат-Эрдэнэ гишүүнээ. 1 дүгээрт төрийн албан хаагчдын цалин бол үнэхээр бага байгаад байгаа юм. 2 дугаарт бид нарын баталж өгсөн Төрийн албаны тухай хууль бол ялангуяа сумдад очоод энэ тавигдах шаардлагад нь нийцэх тийм олон шаардлага хангасан албан тушаалтан бол бас хэцүү юм билээ. Түрүүн хэлсэнчлэн БОАЖЯ бол өөрсдөө ирээд манай ойн хамгаалагчид бол бүгдээрээ төрийн захиргааны албан хаагчид байгаа, дээд боловсролтой, наад олон шалгуурыг чинь хангах хүн бол байхгүй байна гэдэг шиг. Яг л ийм нөхцөл байдал бас үүсчхээд байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ Төрийн албаны тухай хуулиа бид нар Улсын Их Хурал бас дахин 1 дүгээрт бас харах хэрэгтэй юм байна лээ. Бидний түвшинээс бол ямар ч байсан хот, хөдөө гэж ялгахгүй төрийн захиргааны, төрийн тусгайгийн, төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг сая төгрөг боллоо. Ингээд үүнээсээ дээшээ ангилал зэрэглэлээрээ бол нэмэгдээд явна гэсэн үг. Тэгэхээр хот, хөдөө гэлтгүй нэмэгдэнэ. 2 дугаарт дээрээс нь нэмээд орон нутгийн нэмэгдлийг босоо, хэвтээ гэхгүй орон нутаг нь шийдэхээр Засгийн газрын тогтоолоор бид нар бас чиглэл өгөх гэж байна. Яагаад гэвэл энэ төсвийн тодотголын дараагаар орон нутгууд бас

төсвийнхөө тодотголыг хийнэ. Цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор орон нутгийн орлого ч гэсэндээ бас нэмэгдэхээр бас байгаад байгаа юм.

2 дахь асуудлын хувьд энэ тэтгэврийн зөрүү яг таны хэлж байгаа үнэн. Сая энэ 22 оны нэмэгдлээр бол бараг тэтгэвэр авагчдын 20 хувь нь бол тэтгэврийн доод хэмжээнээс дээшээгээ 500 мянга болоход ахиад тэтгэврийн доод хэмжээ рүү орчихсон. Дээрээс нь нэмээд итгэлцүүрийг бид нар бас жил болгон нэмж байгаагүйтэй холбоотойгоор маш олон тэтгэвэр авагчдын тэтгэвэр нь инфляцад идэгдээд, тэтгэврийн доод хэмжээ рүү бас орчихоод байгаа юм. Тэгэхээр одоо мөрдөж байгаа хуулийн дагуу бол уг нь бол бараг л жил болгон л энэ тэтгэврийн итгэлцүүрийг батлаад, тэтгэврийг ингээд шинэчлээд явах ёстой байсан чинь 95 оноос хойш 6 удаа л баталсан. Хамгийн сүүлийнх нь 2014 онд баталсан. Тэгээд үүнээс хойш өөрөөр хэлбэл иргэдийн тэтгэвэр ингээд инфляцтай бид нар бас уялдуулж тэтгэврийн зөрүүг арилгах ажлыг бид нар бас хийгээгүй явсны үр дүнд өнөөдөр одоо ярихаар бүр шинэ содон ойлголт шиг хүмүүс яриад байгаа байхгүй юу. Уг нь энэ чинь ингээд байнга хийгдээд явах ёстой.

Одоо Нийгмийн даатгалын багц хууль дээр жил болгон Засгийн газар тогтооно. Ингээд тогтоогоод явахаар яах вэ гэхээр шинээр тэтгэвэр гарч байгаа хүмүүс дээр л ерөнхийдөө үйлчлээд явна. Хоёрт дээрээс нь нэмээд бид нар тэтгэврийг жил болгон инфляцтай уялдуулж нэмэгдэж байж, иргэдийн тэтгэвэр инфляцад идэгдэхгүй, тэтгэврийн зөрүү үүсэхгүй ийм нөхцөл байдал үүсэх юм байна лээ. Одоогийн хууль дээр бол угаасаа нөгөө Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх журмын тухай хуульд итгэлцүүр хэрэглэх энэ зохицуулалт бол байж байгаа юм. Тэгээд хамгийн сүүлд бол 2014 онд л хэрэглэсэн ийм нөхцөл байдалтай байгаа юм байна лээ.

Б.Саранчимэг: Баярлалаа. 5 номерын микрофон дээр нэмж хариулъя. Хөдөө аж ахуйн яамнаас өөрийгөө танилцуулаад хариулаарай.

Д.Тунгалаг: Энэ өдрийн мэнд хүргэе. Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Тунгалаг. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд малын гоц халдварт өвчний гаралтын талаар бас тойм мэдээг өгье. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 2 төрлийн гоц халдварт өвчний гаралт улсын хэмжээнд бүртгэгдээд, тэмцэх арга хэмжээ хэрэгжиж байна.

1 дүгээрт нь бог малын мялзан өвчний гаралт одоогийн байдлаар 9 аймгийн, 24 сумын 30 голомтод хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2 дахь гоц халдварт өвчин нь бол бог малын хонины цэцэг өвчин. Хонины цэцэг өвчний гаралт бол өнөөдрийн байдлаар 3 аймгийн 8 сумын 14 голомтод хорио цээрийн арга хэмжээ хэрэгжиж байна. Энэ өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 23 онд бол нийт мал эмнэлгийн салбарт бол 60 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Үүнийхээ хүрээнд гоц халдварт өвчинтэй тэмцэх ажилд бол 41,7 тэрбум төгрөгийг, 4 гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсний дагуу одоогийн байдлаар бол улсын хэмжээнд хаврын дархлаажуулалт, сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлууд зохион байгуулагдаад явж байна.

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил бол 5 сарын 29-нөөс төвийн болон говийн бүсийн, төвийн бүсийн нийт 14 аймгийн 198 сумын 19 сая малыг дархлаажуулах ажил эхлээд явж байна. Өнөөдрийн байдлаар 12,8 хувийн гүйцэтгэлтэй явж байна. Дараагийн дархлаажуулалтыг бол үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Дорнод аймгийн 14 сум, Сүхбаатар аймгийн 2 сум гээд эрсдэл

бүхий ийм 16 сумд 3 сарын 15-наас эхлээд 870 орчим мянган үхрийн дархлаажуулалтын ажлыг хийгээд дууссан. 3 дахь ажил нь бол шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд энэ жил 9 сая тун вакцин нөөцөд байсан 6,5 сая тун вакцинаар 2 удаагийн давтан дархлаажуулалт хийнэ.

Хаврын 1-д дүгээр ээлжийн дархлаажуулалтыг 4 сарын 15-наас улсын хэмжээний нийт өвчлөмтгий үхэр сүргийг дархлаажуулах ажил хийгдэж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар бол нэг улсын хэмжээнд 77 хувьтай явж байна. Удааширалтай явж байгаа шалтгаан нь бол зүүн болон зарим аймгуудад малын хорогдол ихтэй, байгаль цаг уурын бэрхшээлээс болж мал ихээр хорогдсон, мал их сарнисантай холбогдуулаад дархлаажуулалтын ажил харьцангуй бас жаахан удааширалтай явж байна. Өнөөдрийн байдлаар бол импорттоор 3 төрлийн вакциныг бид бүхэн худалдаж авсан. Нийт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 9 сая тун вакциныг 10,1 тэрбум төгрөг, үхрийн арьс товруутах вакцинаас урьдчилан сэргийлэх 1,2 сая тун вакциныг 1,8 тэрбум төгрөг, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх 20 сая тун вакциныг 4,7 тэрбум төгрөгөөр, дотоодын үйлдвэрээс хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 сая тун вакцины захиалгыг өгөөд одоо үйлдвэрлэлийн шатанд явагдаж байна. 7 сарын эхэн гэхэд үйлдвэрлэлээс хяналт шалгалтдаа батлагдаж гарахаар дархлаажуулалтын ажил хийхээр төлөвлөгдөөд явж байгаа. Нийт батлагдсан төсвийн зарцуулалт өнөөдрийн байдлаар 6 сарын 1-ний байдлаар бол 71 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр Байнгын хорооны тогтоол гарсан шүү дээ. Тэрийгээ та хэд мөрдөж байгаа юу, үгүй юу? Жилдээ 2 удаа хавар, намартаа 6

сарын хугацаатай юу дундаа 6 сарын хугацаатайгаар бүх мэдрэмтгий малдаа вакцин малаа вакцинжуулъя, ингээд нэг 2-оос 3, 5 жилийн хугацаанд малынхаа өвчнөөс салъя, энэ гоц халдварт өвчнөөсөө салъя гэсэн нэг ийм шийдвэр гарсан байх. Тэгээд энийгээ та нар хэрэгжүүлэхгүй байна шүү дээ. Энийгээ яг юу гэж бодож байгаа юм бэ? Би энийг л асуугаад байгаа юм.

2 дугаарт Байнгын хорооны дарга та энэ дээр нэг анхаарал хандуулаад, энэ чинь Байнгын хорооноос гарсан тогтоол ерөөсөө хэрэгжихгүй яваад байгаа байхгүй юу. Засгийн газар дээр ерөөсөө тоохгүй байна наадах чинь. Тэгэхээр энийг хэдүүлээ нэг бүүр дараа нь яг мал амьтныхаа эрүүл мэндтэй холбоотой асуудал дээр, энэ малын өвчлөлтэй холбоотой асуудал дээр дахиад Байнгын хорооны тусад нь сонсмоор байгаад байгаа юм. Ийм саналыг оруулж ирж байна.

Б.Саранчимэг: Санал байна. Тэгэхдээ Болорчулуун сайдад бас хэлэх хэрэгтэй байна. Яг ийм чухал асуудал хэлэлцэж байхад өөрөө ч оролцохгүй, тэгээд ингээд явж байдаг. Тэгээд тэрийгээ бас сайддаа хэлээрэй. Одоо нэмж тэгвэл 5 номероос нэмж хариулах уу? Саяын асуудлаар. Сүүлийн асуудлаар, 5 номерын микрофоныг өгье.

Д.Тунгалаг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. 2023 оны урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөгөө бол бид хэд Улсын Их Хурлын Байнгын хорооноос өгсөн 04 тоот тогтоол, түр хорооноос өгсөн 02 дугаар тоот тогтоолын хүрээнд төлөвлөлтийн ажлыг хийж байгаа. Батлагдсан төсвийнхөө хэмжээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг улсын хэмжээнд зөвхөн үхэр, мэдрэмтгий үхэр сүрэг дээрээ 6 сарын хугацаатай 2 удаа дархлаажуулах ажлын эхний ээлжийн дархлаажуулалт хийгээд ингээд явж байна. Байнгын хорооноос өгсөн тогтоол дээр бол 04 дүгээр тогтоол дээр 12 зүйл заалтыг бол бид бүхний ажил дээр

нэмэлтээр үүрэг чиглэл өгсөн. Үүний хүрээнд өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлуудыг бид бүхэн технологийнхоо хугацаанд зохион байгуулаад явж байгаа.

Б.Саранчимэг: Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Энэ удаагийн тодотголыг бол дэмжиж байгаа. Өмнөх тодотголуудаас нэг онцлогтой нь бол шууд ард иргэдийн гар дээр цалин болж нэмэгдэж очиж байгаа нь бол сайн хэрэг. Нөгөө талаас бол энэ цаашидаа салбарууд дур зоргоороо цалингаа нэмдэггүй Засгийн газар энэ цалин хөлсний нэгдсэн бодлоготой болж байгаа хамгийн том давуу тал гэж бодож байна. Тэгэхээр цаашидаа бол энэ яамнууд аль нэгэн салбар нь цалингаа дураараа нэмдэггүй, Засаг хэрэв нэмэх юм бол улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор нэг хувиар нэмэгдээд явдаг ийм тогтолцоо руу орж байна гэж ингэж ойлгож байгаа юм. Тэгэхээр энэ орж ирж байгаа яг манай Байнгын хороон дээр орж ирж байгаа тодотголттой холбоотой бол энэ зөвхөн цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой л тоо орж ирж байгаа учраас энэ дээр нэг их асуугаад байх юм байхгүй.

Зүгээр төсвийг бүхэлд нь харахаар бол энд орж ирсэн 5 яамных бол дотроо ямар ч хөдөлгөөнгүй байгаа юм. Зарим яамдынх бол зардлын зүйл ангиуд нь хоорондоо гүйчихсэн юмнууд байна лээ л дээ. Тэр нь яг болох юм уу, үгүй юү Жавхлан сайдаа? Зөвхөн бид нар чинь цалин, тэгээд энэ нэг түгжрэл дээр нэг хэдэн төгрөг тавья л гэсэн юм ярьсан. Тэгээд бусад нь хоорондоо гүйж болж байна уу, үгүй юү гэдгийг асууя. Салбарын зардал нь зардал дотроо хөдөлгөөн.

Тэгээд байна шүү дээ би зүгээр энэ Байнгын хорооны даргаас Байнгын хороон дээр бид нар энэ зөвхөн энэ асуудлуудыг хэлэлцэх юм уу, дагах хуулиуд дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад, Төсвийн байнгын хороо руу оруулах боломж байгаа юу? Тэгэх юм бол би дагах хууль

дээр хэдэн юм яримаар байна. 1 дүгээрт нь бол энэ Нийгмийн даатгалын багц хууль орж ирж байгаатай холбоотой төрийн албан хаагчдын цалин нэмэгдчихэж байгаа юм. Тэгэхээр манайх яг Хөдөө аж ахуйн байнгын хорооны хувьд хөдөөгийн малчдаас тэд нар ямар цалин хөлс гэж байх биш. Тавьж байгаа нэг хүсэлт нь бол өмнө нь бид нар нэг НДШ-ийг нэг нөхөн төлүүлэх нэг хууль гаргаад хэрэгжиж байсан юм. Тухайн үед нь бол ойлгохгүй олон хүмүүс энийг нөхөн төлж чадахгүйгээр хохироод үлдсэн л дээ. Одоо энэ хөдөөгийн малчдын зүгээс тавьж байгаа хүсэлт бол нэг жилээр ч гэсэн энэ НДШ-ийг нөхөн төлүүлэх энэ хуулийг нэг хэрэгжүүлж өгөөдөх гэдэг ийм хүсэлт тавиад байгаа юм. Энийг ингээд энэ хуулийн дагасан хуулиар оруулах юм бол боломж байгаа юу гэдгийг би салбарын сайдаас асуух гээд байна.

2 дугаарт нь ХАА-н салбар дээр бас л энэ ХАА-н салбарынхан бол энэ төрөөс авч байгаа цалин хөлс бол бага. Энэ агуулгаараа сая тэр малын эрүүл мэнд гээд юм ярьж байна. Хөдөөгийн бүх багууд дээр энэ хувийн мал эмнэлгүүд байгаа. Энэ хүмүүс бас л нөгөө цалин хөлс дагаад энэ төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний тарифын асуудал яаж явж байгаа вэ? Энэ тодотголыг дагаад энэ малын эрүүл мэнд вакцинжуулалттай холбоотой энэ үйлчилгээний тариф нэмэгдэх тал дээр энэ Хөдөө аж ахуйн яам энэ саяын төсвийн тодотголоор энэ Сангийн яамтай ярьж, орон нутгийн хөгжлийн сан дээр энэ тодотгол хийх тал дээр анхаарсан зүйл байна уу?

Дагах хууль дээр би нэг хэдэн зүйл байгаа юм. Төрийн хэмнэлтийн хууль. Төрийн хэмнэлтийн хуулиар сая бид нарыг хөдөө орон нутагт явж байхад бол маш олон саналууд тавьж байна. Төрийн хэмнэлтийн хуулийг дагаад энэ сумын иргэдийн хурлын дарга нар нь унаа мал байхгүй болсон. Аймгийн Засаг даргын орлогч нар чинь яг аймгийн гол ажлыг хийгээд явж байдаг хүмүүс унаа мал унах эрхгүй болсон. Энийг бас энэ дагах хууль дээр Төрийн хэмнэлтийн хууль дээр нэг

сумын иргэдийн хурлын дарга нарыг нэг унаа мал унах эрхийг нь, нэг аймгийн Засаг даргын орлогч нарыг нэг машин унаа унах эрхийг нь олгох боломж байгаа юу?

2 дугаарт нь энэ Төрийн хэмнэлтийн хууль дээр бид нар чинь энэ хөрөнгө оруулалтыг 5 сарын 31 байх. Тэрнээс хойш хэрэгжүүлж чадаагүй бол төсвийг нь эргүүлэн татдаг нэг ийм.../минут дуусав/

Б.Саранчимэг: Манай энэ төсвийн тодотголтой холбогдуулж орж ирэх дагалдах хуулиуд бол манай Байнгын хороогоор орохгүй. Нийгмийн бодлогын байнгын хороогоор орж байгаа. Одоо 11 цагаас хуралдаж байгаа, тэрийг бас тодруулж хэлье. Тийм. Холбогдох Байнгын хороогоор нь ороод явчаж байгаа. Ганболд гишүүний асуултад эхлээд Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ганболд гишүүний асуултад хариулъя. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийнхөө төсөв дотроо урсгалыг нь урсгал дотроо, хөрөнгө оруулалтуудыг бол бас тооцоо судалгаатай байх хэрэгтэй. отроо шилжүүлж бол болно тийм. Тэгээд Сангийн яамтайгаа бидэнтэй ирж юугаа танилцуулаад, сар, сар, улирал улирлаараа хуваариа батлуулж аваад ингээд хийж зохицуулалт хийчхэж болно. Тэр нийгмийн даатгалын нөхөн төлүүлэх эд нарыг Булгантуяа сайд хариулсан нь дээр байх. Тэгэхдээ ер нь бол манай санал энэ нөхөн төлүүлэх хугацаа хангалттай өгсөн, нэг удаа сунгасан, одоо дахиад сунгаад хэрэггүй.

Б.Саранчимэг: Булгантуяа сайдын микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Энэ тэтгэврийн даатгалын сан дээр ер нь бол нөгөө нөхөн төлөх хуулиуд бол их ачаалал авчирдаг хуулиуд байна лээ. Бид нар бас өөрсдөө энэ дээр анхаарахгүй бол. Жишээлбэл 2012 оны ажилласан жил, тэтгэврийн дадлагын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиар 608 мянган хүн 38 тэрбум

төгрөгийн төлөөд одоо 324 мянган хүн 1,5 бараг 2 их наяд төгрөгийн аль хэдийн тэтгэвэрт авчихсан. Үргэлжлүүлээд энэ 608 мянган хүн үргэлжлүүлээд авна гэсэн үг. Хэдэн их наяд хүрэх юм байгаа юм бүү мэд. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн дадлагын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль түрүүн Жавхлан сайдын хэлсэнчлэн сунгагдсан. 34 мянган хүн 76 тэрбум төгрөг төвлөрүүлээд, одоо 20,5 мянган хүн 205 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бол тэтгэвэр байдлаар бол аль хэдийн авчихсан байна гэсэн үг. Тэгэхээр ингээд бид нар нөгөө нөхөн төлүүлээд байна гэдэг чинь одоо төлж байгаа хүмүүс дээрээ ачаалал өгөөд л, тэтгэврийнхээ сан дээрээ бас их ачаалал өгөөд байна гэсэн үг. Тэгээд үүн дээрээ бид нар бас 1 дүгээрт харж үзэхгүй бол болохгүй.

Яах вэ Нийгмийн даатгалын багц хууль дээр малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчтэй холбоотой бас нэг ганц, хоёр зүйл заалтууд оруулж өгсөн. Ер нь бол хамгийн зөв юм энэ Туваан сая өргөн барьж батлуулсан энэ хууль бол их зөв юм байна лээ шүү. Үүнийг л харин бид нар Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтраад их зөв хэрэгжүүлэх нь хэрэгтэй байх урт хугацаандаа гэж харж байна. Тэгээд энэ хуулиудыг батлуулчхаад одоо бас олон нийтэд бид нарт ойлгуулж чадаагүй юм уу хаашаа юм. Одоо бол манай малчдын 20 гаруй хувь нь л НДШ төлж байгаа шүү дээ. Тийм. Тэгэхээр бид нар уг нь бол ингээд бараг л хамрагдалт 70 хувь болчихно гэсэн. Тэгээд болохгүй байгаад байгаа юм байна лээ. Тэгэхээр хамгийн зөв нь Туваан гишүүний хуулийн хэрэгжилтийн араас л бид нар илүү их ач холбогдол өгч ажиллала л гэж бодож байна.

Б.Саранчимэг: Хөдөө аж ахуйн яамнаас 5 номер нэмж хариулъя.

Д.Тунгалаг: Ганболд гишүүний асуултад хариулъя. Улсын хэмжээнд гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 41,7 тэрбум төгрөгийг

баталсан байгаа. Энэ нь бол 4 төрлийн гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд. 2018 онд Мал эмнэлгийн ерөнхий газар шинэ хуулийн дагуу байгуулагдсанаас хойш 2020 онд Хөдөө аж ахуйн яамны сайд, Сангийн яамны сайдын хамтарсан тушаалаар Мал эмнэлгийн үйлчилгээний тарифыг нэг дахин нэмэгдүүлж, одоо бол бод малыг 400 төгрөгөөр, бог малыг 200 төгрөгөөр бол үйлчилгээний хөлсийг олгож байгаа. Тарифыг шинэчлэх нэмэгдүүлэх талаар бол Хөдөө аж ахуйн яамны сайдаас Сангийн яамны сайдад бол санал хүргэгдчихсэн байгаа. Энэ жилийн хувьд бол 41,7 тэрбум төгрөгийн 30 хувь буюу 12 тэрбум төгрөг нь энэ урьдчилан сэргийлэх арга хэмжээний тарилгын үйлчилгээний хөлсөнд төлөвлөгдөөд, эхнээсээ бол энэ ажиллагаа олгогдоод эхлээд явж байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Надад нэг асуулт байна. Тэгэхээр бид нар Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ 2023 оны төсвийн тодотголын 2 дугаар хэлэлцүүлгийг хийж байгаа. Тэгэхээр энэ тодотголоор бол хотын түгжрэл, цалин тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгийг бол бас энэ асуудал шийдэгдээд явах гэж байна. Тийм учраас энийг бол бас дэмжиж байгаа юм. Засгийн газрын танилцуулгаас бас нэг тодруулж асуух зүйлүүд байна. Тэгэхээр энэ танилцуулгад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны 6 сарын 6-ны өдрийн байдлаар ингээд 20,1 хувьтай буюу 598,2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна гэж байна. Тэгэхээр энэ төсвийн жил яг дундаа орж байгаа энэ цаг үед хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт дөнгөж ингээд 20 хувьтай байна гээд гэж ийм танилцуулгад орсон байна л даа. Тэгэхээр энэ үлдсэн энэ хугацаанд энэ хөрөнгө оруулалт маань хийгдээд ирвэл амжих уу? Төлөлт биелэх үү? Хэрвээ яг энэ хугацаанд энэ худалдан авах чинь хийгдээд явахаараа энэ чанар болоод энэ аюулгүй байдал стандартад нөлөөлөхгүй юү гэсэн ийм нэг асуулт байна.

Шинэ сэргэлтийн бодлогын Ногоон хөгжлийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах тогтоолын хүрээнд хэрэгжүүлэх энэ 2023 оны арга хэмжээний хөрөнгө оруулалт бүрэн биелэх боломжтой байгаа юү гэдгийг бас Хөдөө аж ахуйн яамнаас асууя.

Дараагийн асуудал бол эдийн засаг болон энэ төсвийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдэлийн нэгээр нь энэ малын өвчин, цаг агаар, ган зудын эрсдэл байгаа. Тэгэхээр энэ эрсдэлээс үүдсэн ХАА-н салбарын нийлүүлэлт, нийлүүлэлтэд нөлөөлөх өрхүүдийн орлого буурах, тэгш бус байдлыг бий болгох эрсдэлтэй байна. Тэгэхээр энэ эрсдэлийг ингээж тооцож тодорхойлсон, энэ эрсдэлийг бууруулах арга хэмжээнд ямар арга хэмжээ авч анхаарч байгаа вэ гэсэн нэг ийм асуултууд байна. Асуултад хариулт өгнө үү. Эхлээд Сангийн Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Юмнаас асууя гэж байгаад асуусан шүү. Ойлголоо. Тэгвэл манай яг гүйцэтгэлийн мэдээнүүдийг хэн Чимэдсүрэн дарга яриадах.

Б.Саранчимэг: 7 номерын микрофоныг өгье.

Ч.Чимидсүрэн: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимидсүрэн. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл түрүүний хэлснээр 20 гаруй хувьтай явж байгаа. Энэ нь бол өмнөх жилүүдийн дундажтай харьцуулахад бол дундаж түвшинд бага зэрэг илүү хувьтай явж байгаа гэсэн үг. Ер нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бол бид нар гүйцэтгэлийнх нь гүйцэтгэлд нь үндэслээд бол санхүүжилтийг нь бол олгоод явдаг. Санхүүжилтийн ихэнх хувь нь бол үндсэндээ энэ 4 дүгээр улиралд бол 50-иас дээш хувь нь бол гараад явдаг ийм нийтлэг практиктай яваа. Тэгэхээр хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хэвийн явагдаж байгаа.

Б.Саранчимэг: Тэр хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлын тал дээр арга хэмжээний хөрөнгө оруулалтын биелэлт ямар байгаа тал дээр Болорчулуун дарга хариулъя, 5 номерын микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамжийн аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн, түүнийг хэрэгжүүлэх Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол өнгөрсөн оны 6 сарын 17-ны өдөр бол батлагдсан байгаа. Ингээд одоо яг нэг жилийнхээ нүүрийг үзэж байна. Энэ юу тогтоолын хэрэгжилтэд өнгөрсөн жилийн 2023 оны төсөвт сайдын багц дээр 223,4 тэрбум төгрөгийг бол баталж өгсөн. Үүнээс бол 135,5 тэрбум төгрөг нь бол зээлийн хүүгийн татаас хэлбэрээр олгохоор энэ шийдвэрийг төсвийг бол баталж өгсөн. Энэ хүрээнд бид арилжааны 10 банктай хамтарч энэ зээлийн хэрэгжилтийг бол зохион байгуулж ажиллаж байна.

Нэг жил тогтоол Улсын Их Хурлын тогтоол батлагдаад нэг жилийн хугацаа өнгөрч байгаатай холбогдуулан бид бас сая хэрэгжилтийнхээ явцын тайланг бол гаргаж үзэж байгаа. Тэгэхээр ингэхээр бол нийтдээ нийт 114 арга хэмжээг энэ тогтоолын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгаснаас одоо яг нэг жилийн хугацаанд бол 8 арга хэмжээ 100 хувийн биелэлттэй, 20 арга хэмжээ бол 70 хувийн биелэлттэй, 30 арга хэмжээ, 68 арга хэмжээ бол 30 хувийн биелэлттэй, 7 арга хэмжээ бол тэг хувийн биелэлттэй гэсэн байдал ерөнхий урьдчилсан нэг жилийн үнэлгээгээ бол хийж байгаа. Ингээд мэдээж энэ хүнсний хангамжийн 36 дугаар тогтоолын биелэлтэд бол төрийн нийтдээ 34 байгууллагын оролцоо хамтын ажиллагаа байж энэ тогтоол биелэх ёстой. Ингээд салбарын зарим яамнууд дээр ажлууд бас удаашралтай байгаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр зарим ажлууд нь хэрэгжээгүй байгаа гээд ийм асуудлууд байгаа. Энэнийхээ тайланг бид одоо бас

ингээд танилцуулаад, холбогдох арга хэмжээнүүдийг аваад хэрэгжүүлээд явж байгаа.

Хамгийн гол асуудал нь бас энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт буюу арилжааны банкны эх үүсвэр дээр тулгуурласан зээлүүдийг гаргах асуудал байгаа. Энэ асуудал дээр бол арилжааны нийт 10 банкаар 982 орчим тэрбум төгрөгийг энэ хүүгийн татаасанд тулгуурлаж гаргах энэ зохицуулалтыг хийж, Монголбанк, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн ерөнхий зээлийн хэлэлцээрийг байгуулж, арилжааны 10 банктай ажилласны үр дүнд өнөөдрийн байдлаар бол 180 орчим тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэйгээр энэ зээлийн хэрэгжилт бол гараад явж байна гэдгийг хэлье.

Б.Саранчимэг: Болорчулуун даргад баярлалаа. Тэгэхээр ер нь бол энэ хөрөнгө оруулалтын биелэлт бас хангалт муутай л харагдаад байгаа учраас энэ холбогдох Засгийн газрууд, яамнууд анхаарч ажиллаарай гэж хүсье. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу? Над дээр ганц санал ирсэн байна. Тэгэхээр энийг та бүхэнд танилцуулаадахъя.

Төслийн 1 дүгээр хавсралтын 13.3.3 Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар Баянзүрх дүүрэг, Ховд, Хөвсгөл гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийн Хөвсгөл гэснийг Говь-Алтай гэж өөрчлөх. Энэ саналыг Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан гаргасан байна. Тэгээд энэ оруулж ирсэн саналтайгаа холбогдуулаад Энх-Амгалан гишүүн нэг тайлбар хийчих үү? Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Эрхэм Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Энэ 23 оны төсөв дээр энэ нэр андуурагдаад Б.Энх-Амгалан гэдгийг нь аваачаад Л.Энх-Амгалан болгож хаяад, Говь-Алтайд явах ёстой төслийг нь аваачаад Хөвсгөл болгоод хаячихсан юм. Тэгээд энэ бол Төсвийн байнгын хорооны алдаа юм байгаа юм. Тэгээд тэрнээс болоод нөгөө төсөл нь ч хэрэгждэггүй, зарлагдаж өгдөггүй ингээд нэг ийм гацаанд орчихсон юм. Тэгээд нэгэнт нөгөө Төсвийн хууль болоод батлагдчихсан учраас тэр нэрээрээ явах гээд байдаг. Тэгээд энэ нэг жижигхэн алдаанаасаа болоод ингээд төсөл, арга хэмжээ нь хэрэгждэггүй ингээд нам гацсан юм байгаа юм. 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт орохгүй. Зөвхөн төслийн нэр Хөвсгөл гэснийг л Говь-Алтай болгох юм. Энийг гишүүд минь та бүхэн дэмжээд өгөөрэй. Тэр Төсвийн байнгын хорооны алдаа гаргасан нөхдүүд тэр алдаа гаргасан гэдгээ бол хэлнэ биз. Хөдөө аж ахуйн яам ч гэсэн энийг мэдэж байгаа байх тийм ээ Болорчулуун даргаа. Энэ болбол Говь-Алтайн төсөл тийм биз? Тийм, тийм учраас энэ дээр нэг та бүхэн дэмжээд өгөөрэй.

Б.Саранчимэг: Оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналыг, Төсвийн байнгын хорооны, Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэн гишүүн ирж байна уу, асууя. Жавхлан сайд энэ дээр Сангийн сайд нэг хариулт өгөөдөх дөө.

Б.Жавхлан: Яах вэ би яг анх удаа сонсож байна энэ асуудлыг. Энэ удаа тодотголоор бол иймэрхүү зүйлүүдийг ерөөсөө аваагүй л дээ. Өөр Байнгын хороонууд дээр ийм саналууд мэр сэр гарсан. Тэгээд бүгд унасан, хүлээж аваагүй. Тэгээд энэ асуудал хэрвээ үнэхээр яг Энх-Амгалан гишүүний сая ярьж байгаагаар Төсвийн байнгын хороон дээр тийм техникийн алдаа гарсан бол Төсвийн байнгын хорооныхноос өөрсдөөс нь сонсох хэрэгтэй. Тэгээд яг өөрсдийнхөө Байнгын хороон дээрээ энийгээ засах хэрэгтэй, буруугаа хүлээгээд, ийм алдаа гарсан юм гээд.

Тэгээд энэ чинь 2 аймгийн асуудал яригдаж байна шүү дээ. Хөвсгөл аймгийн, Говь-Алтай аймгийн асуудал яригдаж байна. Нэг аймгаас нөгөө аймаг руу чинь зүгээр нэг солих биш энэ чинь бүүр том, бүхэл бүтэн том төсөл, ажил солигдох гэж байна шүү дээ. Тэгэхээр нөгөө аймгаас нь бас сонсох хэрэгтэй. Тийм. Тэгэхээр нөгөө аймгаас үгүй ээ, үгүй Энх-Амгалан сайдаа би, гишүүнээ би эсэргүүцэж байгаа юм биш шүү. Хэдүүлээ яг зарчмаа бариад л, нөгөө аймаг нь ч гэсэн сууж байгаад, Төсвийн байнгын хорооныхон сууж байгаад, Төсвийн байнгын хороон дээрээ энэ, энэ юм болсон юм, ингээд сольё гээд явчихвал зүгээр зөв болох болов уу л гэж бодож байна. Тэгэхээс энд хэрэггүй байх.

Б.Саранчимэг: Энх-Амгалан гишүүний оруулж ирсэн саналыг протоколд оруулаад, тэгээд Төсвийн байнгын хороон дээрээ яг энийгээ бас шийдэх боломжтой юм байна. Тэгэхээр одоо бол санал хураалт байхгүй.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралд оролцсон эрхэм гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа. Тэгэхээр Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд Батжаргал гишүүн танилцуулъя.

11.25 цаг

Хурал дууслаа, баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

